

# **ИТС-ын Монгол дахь ажлын нэгжүүдэд зориулсан гарын авлага**

**2019**

## Өмнөх үг

Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (ГЭЗХАХЯ)-ны дэмжлэгтэй Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-ийн Ази дахь дэд бүс нутгийн санаачлагын эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих (SCSI) хөтөлбөр Их Түмэн санаачлагын (ИТС) механизмын хүрээнд Монгол улсын бүс нутгийн интеграци, хамтын ажиллагаанд оруулж буй хувь нэмэр, гүйцэтгэж буй үүргийг 2011 оноос хойш дэмжин ажиллаж байна.

Энэ дэмжлэгийн хүрээнд ГОУХАН-ийн үйл ажиллагааны чиглэл бол ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгж (АН) хооронд болон ИТС-ын үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцаа холбоог хөгжүүлэх явдал юм. Мөн ИТС-ын механизм, ИТС-ын үр өгөөжийн талаар тодорхой зөв ойлголт Ажлын нэгжүүдэд олгож, Зүүн хойд Азид Монгол улсын бүс нутгийн интеграцид гүйцэтгэх үүргийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн.

2018 оны 10-р сараас эхлэн SCSI-аас Монгол улс дахь Ажлын нэгжүүдийн хамтын ажиллагааны суурийг тавьж, харилцааг хөгжүүлэх үүднээс ИТС-ын Монгол дахь Оролцогч талуудын тогтмол уулзалтууд зохион байгуулж байна. Эдгээр уулзалтуудын үр дүнд ИТС-ын Ажлын шинэ нэгж, хариуцан ажиллах болон ажилладаг мэргэжилтэнүүдэд ИТС-ын тухай, уг механизмийг үр дүнтэй ашигласнаар Монгол улсад бий болох үр өгөөжийн тухай таниулан ойлгуулах үүднээс ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдэд зориулсан гарын авлага боловсруулах шаардлага бий болсон.

Тиймээс тус SCSI хөтөлбөрөөс ИТС-ын одоо ажиллаж байгаа болон цаашид ажиллах ажлын нэгжүүд, хариуцан ажилладаг мэргэжилтнүүдэд ИТС-ын механизм, Монгол дахь Ажлын нэгжүүдийн үүрэг, ИТС дахь оролцоо, тэдгээрийн үйл ажиллагаа хоорондын уялдааг хангаж, туслах үүднээс энэхүү ИТС-ын Монгол дахь ажлын нэгжүүдэд зориулсан гарын авлагыг боловсрууллаа.

## Агуулга

Товчилсон үгс .....	4
1 ИТС-ын тухай.....	5
1.1 ИТС-ын бүтэц зохион байгуулалт.....	5
Их Түмэн бүс нутаг .....	6
2 ИТС-ын Зөвлөл/Хороод болон тэргүүлэх салбарын тухай.....	7
3 ИТС-ын харъяа бусад нэгжүүд .....	9
4 ИТС-ын Ажлын алба .....	11
1 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүд.....	12
1.2 Зорилго.....	14
1.3 Үйл ажиллагааны зарчим.....	14
1.4 ИТС-ын Монгол улсын Үндэсний Зөвлөх.....	14
1.7 ИТС-ын Монгол улсын Үндэсний зөвлөхийн гол үүрэг .....	15
1.8 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжийн гол үүрэг .....	16
1.9 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжийн үйл ажиллагаа, уулзалт.....	17
1.10 Үйл ажиллагааны санхүүжилт.....	18
1.11 Төсөл боловсруулалт .....	18
1.11.1 Техникийн туслалцааны төсөл.....	18
1.11.2 Техник туслалцааны бус төсөл.....	19
2 ИТС-ын Зөвлөл/Хороодын хурал.....	20
2.1 Танилцуулга.....	20
2.2 ИТС-ын Зөвлөл/Хороодын хуралд оролцох.....	21
2.3 Монгол улсад ИТС-ын Зөвлөл/Хороодын хурал зохион байгуулах .....	21
3 Монгол улсад зохион байгуулсан ИТС-ын Зөвлөлдөх хорооны хурал .....	22
4 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдэд зориулсан онлайн платформ.....	23
4.1 Танилцуулга.....	23
4.2 Ерөнхий заавар .....	23
5 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдийн холбоо барих хаяг.....	25
6 ИТС-ын Ажлын албаны холбоо барих хаяг .....	30
7 2019 онд зохион байгуулагдах ИТС-ын хурлууд.....	31
8 Хавсралтууд:.....	36
Хавсралт 1 ИТС-ын Монгол улс дахь АН-ийн тайлангийн загвар.....	38
Хавсралт 2 ИТС-ын хэрэгжүүлсэн төслүүд.....	39

## Товчилсон үгс

АН	Ажлын нэгжүүд
ГИТ	Гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
ГОУХАН	Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ГСХ	Гаалийн салбар хороо
ГЭЗХАХЯ	Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам
ЗХ	Зөвлөлдөх хороо
ЗХА	Зүүн Хойд Ази
ИТБН	Их Түмэн бүс нутаг
ИТС	Их Түмэн санаачлага
ЛСХ	Логистикийн салбар хороо
НҮБ ESCAP	Нэгдсэн үндэстний байгууллагын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг-нийгмийн Зүүн болон Зүүн Хойд Азийн оффис
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОГХА	Оросын Гадаад худалдааны академи
ОНХАХ	Орон нутгийн хамтын ажиллагааны хороо
СБС	Судалгааны байгууллагын сүлжээ
СГБ	Солонгосын Гаалийн байгууллага
СОУЭЗБХ	Солонгосын Олон улсын эдийн засгийн бодлогын хүрээлэн
ССХ	Үндэсний аюулгүй байдлын дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэн
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТГБНХХ	Түмэн голын бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр
ҮЗ	Үндэсний зөвлөх
ХАХ	Хөдөө аж ахуйн хороо
ХОУХХ	Хятадын Олон улсын худалдааны холбоо
ХХАХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХОХ	Худалдаа, хөрөнгө оруулалтын хороо
ЧХГ	Чөлөөт худалдааны гэрээ
SCSI	Ази дахь дэд бүс нутгийн санаачлагын эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих хөтөлбөр

## 1 ИТС-ын тухай

Их Түмэн санаачлага (ИТС) бол Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн дэмжлэгтэй Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Монгол улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Оросын Холбооны Улс (ОХУ) дөрвөн гишүүн улстай Зүүн Хойд Ази дахь Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны механизм юм. 1991 онд эхлүүлсэн уг механизм нь гишүүн улсуудаар удирдуулсан Зүүн хойд Ази (ЗХА) болон Их Түмэн бүс нутаг (ИТБН)-т эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх бүс нутгийн хамтын ажиллагааны платформ болон өргөжсөн билээ.

1995 онд ИТС-ын гишүүн орнуудын Засгийн газраас ЗХА-д, ялангуяа Их Түмэн бүс нутагт тогтвортой хөгжил, үсрэнгүй өсөлтийг бий болгох үүднээс эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой уг механизмийг байгуулах гэрээг үзэглэсэн. ИТС-ын анхааран ажиллах гол тэргүүлэх салбарууд бол тээвэр, худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, эрчим хүч болон байгаль орчин болно.<sup>1</sup>

Гишүүн орнууд 2005 онд хамтын ажиллагааны гэрээгээ үргэлжлүүлэн 10 жилээр сунгахаар тохиролцсон бөгөөд Түмэн Голын Бүс Нутгийн Хөгжлийн Хөтөлбөр (ТГБНХХ) гэсэн нэршилийг өөрчлөн Их Түмэн бүс нутгийг хамарч буй газар зүйн онцлогоос хамааран Их Түмэн Санаачлага гэж нэрлэсэн. Уг санаачлага хамтын ажиллагааны тэргүүлэгч таван салбар (тээвэр, аялал жуулчлал, эрчим хүч, худалдаа, хөрөнгө оруулалт, байгаль орчин)-тай байхаар тогтжээ. 2011-ээс 2016 онуудад ЗХА Орон нутгийн Хамтын ажиллагааны Хороо (ОНХАХ), ИТС-ын ЭКСИМ Банкуудын Холбоо, ИТС-ын Хөдөө аж ахуйн хороо, ИТС-ын Судалгааны байгууллагын сүлжээ зэрэг байгуулагдаж, хөдөө аж ахуй уг санаачлагын 6 дахь тэргүүлэгч салбар болсон.

Дэлгэрэнгүй мэдээллийг ИТС-ын веб хуудас [www.tumenprogramme.org](http://www.tumenprogramme.org) -аас авна уу.

### 1.1 ИТС-ын бүтэц зохион байгуулалт


ИТС-ын шийдвэр гаргагч байгууллага бол гишүүн орон бүрийг төлөөлсөн Дэд сайд нарын түвшний удирдлагуудаас бүрдсэн **Зөвлөлдөх Хороо** юм. **Үндэсний Зөвлөх** бол Зөвлөлдөх хороо, салбарын яамдууд болон Ажлын алба хоорондын зохицуулалт хийх үүрэг бүхий удирдах түвшний ажилтан байдаг. **ИТС-ын Ажлын алба** нь Зөвлөлдөх Хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажилладаг. Тэргүүлэх салбаруудын техникийн түвшин дэх хамтын ажиллагаа, харилцан зохицуулалт, зохион байгуулалтыг хангах үүднээс салбар тус бүр Зөвлөл/хороодтой байдаг. Үүнд: Тээврийн зөвлөл, Худалдаа, Хөрөнгө оруулалтын хороо, Аялал жуулчлалын зөвлөл, Эрчим хүчний зөвлөл, Байгаль

<sup>1</sup> Энэхүү хэсгийг ЗХА ОНХАХ-ны Гарын Авлагаас авав (ИТС 2019).

орчны зөвлөл, Хөдөө аж ахуйн хороо.

Мөн ЗХА-ийн Орон нутгийн хамтын ажиллагааны хороо, Логистикийн салбар хороо, ЗХА-ийн ЭКСИМ Банкнуудын холбоо, ИТС-ын Судалгааны байгууллагын сүлжээ бол ИТС-ын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд өргөжүүлэн нэмэгдүүлэх, хөгжлийн санхүүжилт хийх, эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг харилцан уялдуулж, өргөжүүлэх нөхцөл бололцоог хангах зорилготой ИТС-ын харъяа ажилладаг платформууд юм.

**Зураг 1: ИТС-ын бүтэц зохион байгуулалт**



Эх сурвалж: <http://www.tumenprogramme.org/?list-1529.html>

**Их Түмэн бүс нутаг**

ИТС нь БНХАУ-ын зүүн хойд бүсийн дөрвөн аймаг (Жилин, Хейлонжиан, Ляонин, Өвөр Монгол), Монгол улсын зүүн бүсийн гурван аймаг (Хэнтий, Дорнод, Сүхбаатар), БНСУ-ын зүүн хэсэг (Кангвон, Кёонсангбук, Бусан, Улсан), ОХУ-ын Приморский муж нутгийг хамарсан Их Түмэн Бүс нутгийн эдийн засаг, бүс нутгийн хөгжилд голчлон анхааран ажилладаг билээ. Гэхдээ хамтын ажиллагааны хүрээнд дөрвөн улсын бусад орон нутгийг хамруулдаг. Тухайлбал, ОНХАХ-нд Сэлэнгэ аймаг, БНСУ-ын Жежү арал, Японы Тоттори муж гишүүнчлэлтэй байдаг.

## 2 ИТС-ын Зөвлөл/Хороод болон тэргүүлэх салбарын тухай

ИТС нь зургаан тэргүүлэх салбартай. Үүнд: Тээвэр, Худалбаа ба Хөрөнгө оруулалт, Аялал жуулчлал, Эрчим хүч, Байгаль орчин, Хөдөө аж ахуй. Зөвлөл/хороо нь гишүүн орон тус бүрийн холбогдох Ажлын нэгжүүдээс бүрддэг. Жишээлбэл, Худалдаа ба Хөрөнгө Оруулалтын хорооны Монгол улс дахь Ажлын нэгжээр Монгол улсын Гадаад Харилцааны яам, үүний дотор Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар ажилладаг бөгөөд Худалдаа хөрөнгө оруулалтын хүрээнд ИТС-тай холбоотой асуудлыг хариуцдаг. Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар нь ИТС-ын Аялал жуулчлалын зөвлөлийн Ажлын нэгжээр ажилладаг зэргээр холбогдох яам, газрууд ИТС-ын дээрх 6 Зөвлөл/хороодын Ажлын нэгжээр ажилладаг. ИТС-ын Ажлын албанд тухайн Зөвлөл/хороод тус бүрийг хариуцсан ажилтан байдаг бөгөөд холбогдох салбарын хүрээнд гишүүн орнуудын зохих Ажлын нэгжүүдтэй шууд харилцан үйл ажиллагаагаа явуулдаг. Мөн Зөвлөл/хороо бүрт гишүүн орны холбогдох Ажлын нэгжүүдийн хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөн ажиллах Ажлын удирдамжтай<sup>2</sup> байдаг.

Зөвлөл/хороод нь ИТС-аас боловсруулсан судалгаа, мэдээллээр Ажлын нэгжүүдийг хангахаас гадна өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай аливаа мэдээллээр хангахыг Ажлын нэгжүүдээс шаардаж болдог. Түүнчлэн Ажлын албанаас зохион байгуулагч гишүүн ороны холбогдох Ажлын нэгжүүдтэй хамтран жил тутам явагддаг Зөвлөл/хороодын уулзалтыг зохион байгуулдаг. ИТС нь тэргүүлэх салбарууддаа үндэслэсэн дараах Зөвлөл/Хороодтой<sup>3</sup>.

### Тээврийн зөвлөл

#### ➤ ИТБН-ийн тээврийн дэд бүтэц, харилцаа холбоог сайжруулах

ИТС нь бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, зорчигчдын тээврийн зардлыг бууруулах үүднээс ИТБН-ийн гол ач холбогдолтой боомт, төмөр зам, авто замуудыг холбох замаар бүс нутгийн тээврийн үндсэн корридорудыг байгуулах, хөгжүүлэх зорилготой. Энэ зорилгын хүрээнд 2010 онд ИТС-ын гишүүн орнуудын тээврийн удирдах байгууллагуудын ахлах мэргэжилтнүүдээс бүрдсэн ИТС-ын Тээврийн зөвлөлийг дараах зорилготойгоор байгуулсан:

- ИТБН-т тээвэр, логистикийн биет дэд бүтцийг сайжруулах;
- Хил дамнансан тээвэрлэлтийн үйл ажиллагааг хялбаршуулан биет бус саад тотгорыг бууруулах;

<sup>2</sup> Зөвлөл/Хороодын Ажлын удирдамжийг <https://gti-mongolia.slack.com/messages/CDQLGA1MF/> линкээс үзнэ үү.

<sup>3</sup> Зөвлөл/Хороодын тухай мэдээллийг ИТС-ын веб хуудас: [www.tumenprogramme.org](http://www.tumenprogramme.org) -аас авав.

- ИТБН-т үр ашигтай, аюулгүй, тогтвортой тээвэр, логистикийн үйлчилгээг хөгжүүлэх;
- Зорчигч, ачаа таваарын хил дамнасан болон транзит саадгүй хөдөлгөөнийг нэмэгдүүлэх.

## **Худалдаа ба Хөрөнгө оруулалтын хороо**

### ➤ **ИТБН-т бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих**

Бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүднээс анхлах байгуулагдсан Худалдаа хөнгөвчлөх хороог 2006 онд Худалдаа, хөрөнгө оруулалтын хороо (ХХОХ) болон Гаалийн салбар хороо (ГСХ) болгож өөрчилсөн. ХХОХ болон ГСХ нь тухайн бүс нутгийн худалдааг хөнгөвчилж, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих бололцоог хангах платформ юм. Эдгээр нь дараах зорилготой:

- Худалдааны өртөгийг бууруулах үүднээс техникийн түвшин дэх уялдааг хангах, хялбаршуулах арга хэмжээг дэмжих
- Бүс нутаг хоорондын худалдааг нэмэгдүүлэхэд тулгарч буй гол бодлогын түвшин дэх асуудлуудыг арилгах
- Хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагааг хангах үүднээс төрийн байгууллага, хувийн салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

## **Аялал жуулчлалын зөвлөл**

### ➤ **ИТБН-т аялал жуулчлалын онцгой чиглэл бий болгох**

ИТС-ын Аялал жуулчлалын зөвлөл нь төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талуудыг нэгтгэхийн зэрэгцээ бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай чиглэл, санаачлагыг тодорхойлж, ангилахад туслалцаа үзүүлэх мэргэжилтнүүдийг нэг дор хамтран ажиллуулахаар дараах зорилготой байгуулагдсан.

- Хил дамнасан аялагчдын урсгалыг нэмэгдүүлэх үүднээс олон чиглэлтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх, дэмжих
- Гол чиглэлүүд дэх аялал жуулчлалын орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулах
- Аялалын виз гэх мэт хил нэвтрэхэд шаардлагатай аливаа баримт бичиг, гаалийн бүрдүүлэлт зэргийг хялбарчлахад боломжийг эрэлхийлэх

## **Эрчим хүчний зөвлөл**

### ➤ **ИТБН-т эрчим хүчний бодлого зохицуулалтыг дэмжих**

ИТС-ын Эрчим хүчний зөвлөл нь бүс нутгийн эрчим хүчний асуудлыг бодлогын болон стратегийн түвшинд авч хэлэлцэхээр байгуулагдсанаас гадна хувийн салбарын туршлага, нөөцийг мөн хэлэлцэх асуудалдаа багтаасан. Дараах зорилготой:

- Засгийн газар хоорондын эрчим хүчний бодлого зохицуулалтыг сайжруулах
- Эрчим хүчний худалдаа, хөрөнгө оруулалтын биет бус саад тотгорыг бууруулах
- Гишүүн орнуудын эрчим хүчний хөгжлийн тухай мэдээллийг харилцан солилцоог нэмэгдүүлэх



## Байгаль орчны зөвлөл

### ➤ ИТБН-т байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх

ИТС-ын Байгаль орчны зөвлөл нь байгаль орчин болон эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах үүднээс хөгжлийн сайн туршлагыг хөхиүлэн дэмжин хөгжүүлэх үүднээс дараах зорилготой байгуулагдсан.

- ИТС-ын хамтын ажиллагааны бүх тэргүүлэх салбарууд дахь байгаль орчны асуудал, үр дагаврын тухай авч үзэх
- Тогтвортой хөгжлийн асуудлаар гишүүн орнуудын Засгийн газруудын чадавхийг бэхжүүлэх, улсын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд байгаль орчны хамгааллын асуудлыг нэн чухалчлан оруулах
- Байгаль орчны тогтвортой байдлын тухай олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, бүс нутгийн оролцогч талууд хоорондын түншлэл, харилцааг байгуулах

## Хөдөө аж ахуйн хороо

### ➤ ИТБН-т хөдөө аж ахуйн хамтын ажиллагааг дэмжих

ИТС-ын Хөдөө аж ахуйн хороо бол ЗХА дахь хоёр болон олон талт хөдөө аж ахуйн хамтын ажиллагаа, хөдөө орон нутгийн хөгжил, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа хөнгөвчлөх зэрэг асуудлуудыг дэмжих замаар тухайн бүс нутгийн байгалийн төрөл бүрийн нөөц, хөдөө аж ахуйн боломж, бололцоог бүрэн дүүрэн ашиглахад чиглүүлсэн суурь платформ юм. Уг хороо нь дараах үндсэн зорилготой:

- Хөдөө аж ахуйн салбарын бодлого зохицуулалт, хамтарсан хөрөнгө оруулалт, санхүүжилт, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа хөнгөвчлөх замаар бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих;
- Мэдээлэл, технологи солилцож, инновацийг дэмжих замаар тариалалт, хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой удирдлагыг туршлагыг дэмжин дэлгэрүүлэх;
- Тогтмол ургац хураах тогтвортой үйлдвэрлэлээр бүс нутгийн хүнсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх.

## 3 ИТС-ын харьяа бусад нэгжүүд

Тэргүүлэх салбаруудын хүрээнд бусад талууд тухайлбал олон улсын байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай байнга хамтран ажилладаг. Үүнээс гадна ИТС-ын харьяанд гурван нэгж үйл ажиллагаа явуулдаг: **ИТС-ын ЗХА-ийн Орон нутгийн хамтын ажиллагааны хороо (ЗХА ОНХАХ), ИТС-ын ЗХА-ийн ЭКСИМ Банкуудын Холбоо болон Судалгааны байгууллагын сүлжээ (СБС)**. Энэхүү хамтын ажиллагаа нь ИТС-т хөгжлийн агентлагууд, ТББ, санхүүгийн болон судалгааны байгууллагууд, хувийн салбарын байгууллагууд, гишүүн орнуудын бүс нутгийн орон нутаг дахь удирдлагуудтай хамтран ажиллах бололцоо олгодог.

Зөвлөл/хороод болон эдгээр харьяа нэгжүүд хоорондоо хамтын ажиллагаа, гишүүнчлэлийн

түвшин болон ажиллах цар хүрээгээрээ ялгаатай байдаг. Гэхдээ эдгээр нь бүгд ИТС-ын Ажлын албанд Зүүн хойд Ази дахь ИТС-ын 6 үндсэн салбарын бүс нутгийн интеграци, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд хамтран ажилладаг. Үүнээс гадна эдгээр нэгжүүд нь ИТС-ын хүрээнд бүс нутаг дахь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санал солилцох, хамтран ажиллах, харилцан зөвшилцөх гол платформын үүрэг гүйцэтгэдэг.

## **Зүүн Хойд Азийн Орон нутгийн хамтын**

### **ажиллагааны хороо**

Зүүн Хойд Азийн (ЗХА) Орон нутгийн хамтын ажиллагааны хороо (ОНХАХ) бол орон нутгийн түвшинд ЗХА-ийн эдийн засгийн интеграцийн суурийг тавьж, хамтын хөгжилд хүрэхийн тулд ЗХА-ийн орнуудын орон нутгийн засаг захиргаадын эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих үүрэгтэй платформ юм. 2019 оны байдлаар ОНХАХ нийт 12 гишүүнтэй (БНХАУ: Хейлонжиан муж, Жилин муж, Ляонин муж, Өвөр Монгол, Япон улс: Тоттори муж, Монгол улс: Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Сүхбаатар аймагууд, БНСУ: Бусан хот, Кангвон муж, Жежү тусгай засаглалтай муж). Энэ хүрээнд ОНХАХ нь ЗХА-ын орнуудын бүс нутгийн хөгжлийн талаар мэдлэг, мэдээлэл солилцох, харилцан ойлголцолд хүрэх, харилцаа холбоо тогтоож, яриа хэлэлцээг дэмжих зорилготойгоос гадна ЗХА-ийн орнуудын орон нутгийн засаг захиргаадын чадавхийг бэхжүүлэх замаар тэдгээрийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны оролцоог нэмэгдүүлж, орон нутаг болон төв удирдлага хоорондын бодлого зохицуулалтыг сайжруулан хөгжлийн стратегиудыг уялдуулж, орон нутгийн хамтын ажиллагааны санаачлагад нөөц хуваарилж, олон улсын дэмжлэгийг хандуулах, харилцан ашигтай хамтарсан төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх болон хөрөнгө оруулалт татах боломжтой бүс нутгийн бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн.

Логистикийн салбар хороо (ЛСХ) нь 2014 онд ОНХАХ-ийн хүрээнд ИТБН-т тээвэр, худалдааны логистикийн нөхцөл байдал, үр өгөөж, дэд бүтцийг сайжруулах зорилготойгоор орон нутгийн хамтын ажиллагааны түвшинд байгуулагдсан платформ юм. Энэ зорилгын дагуу ЛСХ бол логистикийн асуудлаар тулгарч буй саад тотгорыг арилгахад орон нутаг, төвийн удирдлага хоорондын бодлогын уялдааг сайжруулах, далай-хуурай газрын туршилтын тээврийн загвар чиглэлээр ачаа тээвэрлэн туршилт хийх замаар логистикийн хөгжлийг нэмэгдүүлэх, тээврийн шинэ туршилтын замаар ачаа тээвэрлэхэд олон улсын дэмжлэгийг чиглүүлэх, нөөц хувиарлахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах болон тухайн бүс нутгийн одоо байгаа тээврийн чиглэл, зам сайжруулах, ачааны усан онгоц, олон улсын логистик, үйлчилгээ үзүүлэгчид буюу тээвэрлэгч компаниуд, ачаа экспортлох, импортлох, худалдааны хэмжээ, зам, чиглэл гэх мэтийн талаар мэдээлэл солилцоход чиглэн ажиллах үүрэгтэй. Одоогийн байдлаар нийт 9 гишүүнтэй (Япон улсын Тоттори муж, БНХАУ-ын Йнкоу хот, Ляонин муж, Жилин муж, Хейлонжиан муж, Өвөр Монгол, БНСУ-ын Канвонг муж, Бусан хот, Монгол улсын Дорнод аймаг).

## **Зүүн Хойд Азийн ЭКСИМ Банкуудын Холбоо**

Бүс нутгийн хөгжлийн санхүүжилтийн механизмын хувьд ЗХА-ийн ЭКСИМ Банкуудын Холбоог ИТС-ын санаачласнаар Зүүн хойд Азийн бүс нутаг дахь бүс нутгийн худалдааг дэмжих, бүс нутгийн хөгжлийн төслийг санхүүжүүлэх төрийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх зорилготойгоор байгуулсан. Мөн тус холбоо нь тухайн бүс нутагт тогтвортой хөгжлийг бий болгох нөхцөлийг нэмэгдүүлж, бүс нутгийн интеграцийг бэхжүүлэхэд дэм болно. Холбооны гишүүдээр Хятадын ЭКСИМ банк, БНСУ-ын ЭКСИМ банк, **Монгол улсын Хөгжлийн банк**, Оросын Хөгжил, гадаад эдийн засгийн харилцааны банк болно.

## **Судалгааны Байгууллагын Сүлжээ**

ИТС-ын Судалгааны байгууллагын сүлжээ бол тухайн бүс нутагт нэгдсэн чиглэл, хандлага, хөгжлийн боломж авчрах үүднээс эдийн засгаар хамтран ажиллах боломжийг бий болгох замаар хөгжлийн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлыг нэн тэргүүнд явуулж, урт хугацааны үр дүнтэй эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны механизм юм. Тус сүлжээ нь ИТС-ын гишүүн орнуудын тэргүүлэх үндэсний судалгааны хүрээлэн, байгууллагаас бүрдсэн бөгөөд Хятадын Олон улсын худалдааны холбоо (ХОУХХ), Оросын Гадаад худалдааны академи (ОГХА), Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэн (ССХ), Солонгосын Олон улсын эдийн засгийн бодлогын хүрээлэн (СОУЭЗБХ) гишүүнээр байдаг.

## **4 ИТС-ын Ажлын алба**

ИТС-ын Ажлын алба нь ИТС-ын Зөвлөл/хороодын үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлж, ИТС-ын гишүүн орнуудын Ажлын нэгж хоорондын ажлын уялдааг хангах, гишүүд хоорондын харилцаа холбоог хангах, ИТС-ын уулзалтуудыг тухайн уулзалт зохион байгуулж буй ороны холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мөн төсөл хэрэгжүүлэх үүрэгтэй.

2019 оны 2-р сарын байдлаар тус Ажлын албанд албаны захирлыг оролцуулаад нийт 9 ажилтан гишүүн орон тус бүрээс холбогдох салбарт нийт 3 жилийн хугацаатайгаар томилогдон ажиллаж байна. Ажилтан тус бүр тодорхой тэргүүлэх салбар тухайлбал тээвэр, худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, байгаль орчин, хөдөө аж ахуй, бусад нэгжүүдийг хариуцан ажилладаг.

ИТС-ын Ажлын алба нь БНХАУ-ын Бээжин хотноо байрладаг (1-1-142 Tayuan Diplomatic Compound, 1 Xindong Road, Beijing 100600, PR China) ба албан ёсны веб хуудас нь [www.tumenprogramme.org](http://www.tumenprogramme.org). Ажлын албаны ажилтнуудын талаарх нарийвчилсан мэдээлэл, холбоо барих хаягийг 6-р Хэсгийн хүснэгтээс үзнэ үү.

# 1 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүд

2019 оны 2-р сарын байдлаар Монгол улсад 15 төрийн болон төрийн бус байгууллагын нийт 32 албан хаагч, ажилтан ИТС-ын Ажлын нэгж буюу Хариуцан ажиллах ажилтнаар ажиллаж байна. Эдгээрт Монгол улсын салбарын яамд, холбогдох байгууллагууд, орон нутгийн засаг захиргаад, ТББ хамарч байна.

## Хүснэгт 1: ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүд<sup>4</sup>

№	ИТС-ын Зөвлөл /Хороод	Гишүүд	Монгол улсад ИТС-ын Ажлын нэгжээр ажиллаж байгаа газар/хэлтэс
1	Тээврийн зөвлөл	Зам тээврийн хөгжлийн яам	Бодлого, төлөвлөлтийн газар
2	Худалдаа, хөрөнгө оруулалтын хороо	Гадаад харилцааны яам	Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар
3	Гаалийн салбар хороо	Гаалийн ерөнхий газар	Гадаад хамтын ажиллагааны хэлтэс
4	Эрчим хүчний зөвлөл	Эрчим хүчний яам	Бодлого, төлөвлөлтийн газар
5	Байгаль орчны зөвлөл	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагааны газар
6	Хөдөө аж ахуйн хороо	Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам	Гадаад хамтын ажиллагааны хэлтэс
7	Аялал жуулчлалын зөвлөл	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар
8	ЗХА Орон нутгийн хамтын ажиллагааны хороо	Донод аймаг	Засаг даргын Тамгын газар
		Хэнтий аймаг	Гадаад харилцааны хэлтэс
		Сүхбаатар аймаг	Гадаад харилцааны хэлтэс
		Сэлэнгэ аймаг	Засаг даргын Тамгын газар
9	ЗХА ЭКСИМ Банкуудын холбоо	Монгол улсын Хөгжлийн банк	Актив, пассив, хөрөнгийн удирдлагын газар

<sup>4</sup> ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдийн холбоо барих хаягийг 5-р Хэсгийн хүснэгтээс үзнэ үү.


10	ЗХА Бизнесийн Холбоо	Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхим	Гадаад харилцаа, худалдаа, хөрөнгө оруулалтын газар
11	Судалгааны байгууллагын сүлжээ	Стратеги судалгааны хүрээлэн	Эдийн засгийн бодлогын газар

Улс дотроо **ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүд** нь **Үндэсний зөвлөх** (Сангийн яам)-тэй шууд харилцан ажиллана. Үндэсний зөвлөх (ҮЗ) нь ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдийг төлөөлөн жилд хоёр удаа болдог ИТС-ын ҮЗ-ийн уулзалт болон жилд нэг удаа болдог ИТС-ын Зөвлөлдөх Хорооны уулзалтанд оролцдог. Хэрэв шаардлагатай бол Үндэсний зөвлөхөөс Монгол улсын Ажлын нэгжүүдэд ИТС-ын Ажлын албатай ажиллах талаар чиглэл өгөхийн зэрэгцээ зарим тохиолдолд стратегийн дэмжлэг үзүүлж болно. Ажлын нэгжүүд ИТС-ын Ажлын албатай төслийн санал, арга хэмжээ, уулзалт зэрэг асуудлын хүрээнд явуулж буй ажил хэргийн бүх харилцааны талаар Үндэсний зөвлөхөд заавал мэдээлж байх ёстой.

Мөн улс дотроо ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүд бусад ажлын нэгжүүдтэйгээ шууд харилцан, хамтран ажиллах боломжтой.

Улсаас гадна **ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүд** ИТС-ын **холбогдох Зөвлөл/хороод** болон **ИТС-ын Ажлын алба**-тай шууд харилцан ажиллана. ИТС-ын Ажлын албанаас ИТС-ын гишүүн орнуудын Ажлын нэгжүүд болон ИТС-ын Зөвлөл/хороодыг холбож, харилцан уялдааг зохицуулах үүргийнхээ дагуу ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэн ажиллана. Ажлын алба болон ИТС-ын Зөвлөл/хороод нь ИТС-ын Зөвлөл/Хороодын уулзалт, ИТС-ын ээлжит уулзалтуудыг зохион байгуулах болон Монгол улсад төсөл хэрэгжүүлэхэд Монгол улсын Ажлын нэгжүүдтэй хамтран ажиллах үүрэгтэй.

## Зураг 2: ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжийн ажиллах талууд



## 1.2 Зорилго

ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдийн гол зорилго бол ЗХА-д Монгол улсын бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийг эрчимжүүлэх, үүний тулд Монгол улсын холбогдох салбар, орон нутгийн түвшинд ИТС-ыг сурталчлан таниулах болно. Уг зорилгыг биелүүлэхийн тулд Ажлын нэгжүүд дараах үндсэн зорилтуудтай:

- ЗХА-д Монгол улсын бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийг дэмжих;
- ИТС-ын хүрээнд ЗХА-ийн орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн идэвхижүүлэх;
- ИТС-ын механизмд Монгол улсын Засгийн газрын байр суурь, бодлого, зорилго илэрхийлэх;
- ИТС-ын Зөвлөл/Хороод болон Монгол улсын холбогдох салбарын яамд хоорондын хамтын ажиллагааг хангах;
- Салбар хүрээнд ИТС-ыг таниулан сурталчлах;
- Салбарын хүрээнд ИТС-ын механизмийн талаарх байгууллагын ой санамж хадгалах.

## 1.3 Үйл ажиллагааны зарчим

ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүд дараах үйл ажиллагааны зарчмыг баримтлана:

- ЗХА-ийн интеграцийн тухай бүс нутгийн хэмжээнд нэгдсэн ойлголттой байх;
- ИТС-ын механизмын хүрээнд Монгол улс дотроо харилцан үр ашигтай, нэгдсэн хамтын ажиллагаатай байх;
- Ажлын нэгжийн хувьд ИТС-ын механизмд идэвхитэй оролцож, үр дүнтэй хамтын ажиллагаатай байх;
- Харилцан хэлэлцэж, зөвшилцсөний үндсэн дээр шийдвэр гаргадаг байх.

## 1.4 ИТС-ын Монгол улсын Үндэсний Зөвлөх

2013 оны 7-р сарын 09-ны өдрийн Засгийн газрын 265-р тогтоолын дагуу Монгол улсын Сангийн яам нь ИТС-ыг хариуцан ажиллах байгууллагаар томилогдсон. 2018 оны 04-р сарын 15-ны өдрийн Сангийн сайдын тушаалаар Монгол улсын Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын даргыг ИТС-ын Монгол улсын Үндэсний зөвлөхөөр томилсон.

ИТС-ын Монгол улсын Үндэсний зөвлөхийн гол зорилго бол ЗХА-д Монгол улсын бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийг эрчимжүүлэхэд оршино. Энэ зорилгын хүрээнд

Үндэсний зөвлөх дараах зорилтуудтай байна:

- ЗХА-д Монгол улсын бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийг дэмжих;
- ИТС-ын хүрээнд ЗХА-ийн орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн идэвхижүүлэх;
- ИТС-ын механизмд Монгол улсын Засгийн газрын байр суурь, бодлого, зорилго илэрхийлэх;
- ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдэд стратегийн дэмжлэг үзүүлэх;
- ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжүүдийн хамтын ажиллагааг зохицуулах; ИТС-ын хүрээнд хамтран ажиллах нэгдсэн арга замаар хангах;
- Монгол улсад ИТС-ыг таниулан сурталчлах;
- ИТС-ын холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах;
- Монгол улсад ИТС-ын механизмийн талаарх байгууллагын ой санамж хадгалах.

## 1.7 ИТС-ын Монгол улсын Үндэсний зөвлөхийн гол үүрэг

1. ИТС-ын механизмд Монгол улсын Засгийн газрын байр суурь, бодлого, зорилго илэрхийлэх
  - Монгол улсын Засгийн газрын өмнөөс жил тутмын ИТС-ын Зөвлөлдөх хорооны хурал, улирал тутмын Үндэсний зөвлөхийн хуралд оролцох
  - Монгол улсын Засгийн газрын өмнөөс ИТС-ын бусад гишүүдэд Монгол улсын бодлого, байр суурь, зорилго илэрхийлэх
  - ЗХ-ны хурал, ҮЗ-ийн уулзалтаар гаргасан шийдвэрийг Ажлын нэгжүүдэд танилцуулах
2. Монгол улс дахь ИТС-ын оролцогч талуудын хамтын ажиллагааг зохицуулах
  - Монгол улсын ИТС-ын Ажлын нэгжүүдийн үүргийг тодорхойлох, тэдгээрийн томилгоо, үүрэг, хариуцлагын талаар албан тоотоор мэдээлэх
  - Ажлын нэгжүүдээс ИТС-ын механизмийн хүрээнд арга хэмжээнд оролцсон тухай **жил тутмын тайлан**<sup>5</sup> цуглуулах, нэгтгэх
  - Монгол улс дахь ИТС-ын Ажлын нэгжүүдийн уулзалт тогтмол зохион байгуулах
  - Монгол улс дахь ИТС-ын Ажлын нэгжүүдийн веб платформын хэлэлцүүлэгт идэвхитэй оролцох, тус веб платформын админы үүрэг гүйцэтгэх
  - ИТС-ын механизмийн хүрээнд Монгол улс дахь зарим Ажлын нэгжүүдийн байгуулсан хамтарсан ажлын хэсэгт мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, зөвлөлгөө өгөх
3. Монгол улсад ИТС-ыг таниулан сурталчлах

<sup>5</sup> Тайлангийн загварыг 1-р Хавсралтаас үзнэ үү.

- Монгол улсын холбогдох салбарын яамдуудад ИТС-ын үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах
  - ИТС-ыг таниулан сурталчлах, салбарын яамдуудыг идэвхижүүлж, ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх
4. ИТС-тай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах
- Ажлын нэгжүүд ИТС-ын баримт бичгүүдийн (ИТС-ын Техникийн туслалцааны төслийн санал боловсруулах гарын авлага, ИТС-ын Стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөө гэх мэт) талаар зөв мэдээлэлтэй байж, дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах
  - Ажлын нэгжүүдээс төслийн санал, санааг тогтмол шаардах
  - Монгол улсад төсөл амжилттай хэрэгжих нөхцөл байдлыг хангах
  - Монгол улсад төлөвлөсөн ИТС-ын Зөвлөл/Хороодын жил тутмын уулзалт зохион байгуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

## **1.8 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжийн гол үүрэг**

1. ИТС-ын механизмд Монгол улсын салбарын яам, байгууллага, орон нутгийн удирдлагын байр суурь, бодлого, зорилго илэрхийлэх
  - Монгол улсын яам, байгууллага, орон нутгийн удирдлагын өмнөөс Монгол улсын салбарын бодлого, байр суурь, зорилгыг ИТС-ын бусад Зөвлөл/Хороодын гишүүдэд илэрхийлэх
  - ИТС болон ЗХА-ийн бусад холбогдох байгууллагуудын зохион байгуулж буй хурал/уулзалтанд оролцох
  - Монгол улсад ИТС-ын хүрээнд зохион байгуулж буй уулзалт, зөвлөлгөөн, хэлэлцээрийн зохион байгуулалтанд туслах
2. ИТС-ын Зөвлөл/Хороод болон Монгол улсын салбарын яамд, байгууллага, орон нутгийн удирдлага хоорондын хамтын ажиллагааг хангах
  - ИТС-ын Зөвлөл/Хороодтой тогтмол хамтран ажиллах
  - ИТС-ын Техникийн туслалцааны төслийн санал боловсруулах гарын авлагын дагуу төслийн санал боловсруулж, ИТС-ын Ажлын алба эсвэл холбогдох Зөвлөл/Хороодод үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд өргөн барих
  - Төсөл хэрэгжүүлэх
  - Монгол дахь ИТС-ын Ажлын нэгжүүдийн веб платформын хэлэлцүүлэгт идэвхитэй оролцох
3. Салбарын хүрээнд ИТС-ыг таниулан сурталчлах
  - ИТС-ын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл холбогдох талуудад өгөх



- Салбарын хүрээнд ИТС-ын механизмийг таниулан сурталчлах, ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаанд холбогдох талуудын оролцоог нэмэгдүүлэх
4. Салбарын хэмжээнд байгууллагын ой санамжийг хадгалах
- Хагас жил тутамд Монгол улсын Ажлын нэгжүүдийн холбоо барих хаягийн мэдээлэл, өөрчлөлтийн талаар ИТС-ын Ажлын алба, холбогдох Зөвлөл/Хороодод мэдээлэх
  - ИТС-ын механизмийн хүрээнд оролцосон үйл ажиллагааны талаарх жил тутмын тайлан гаргаж, ИТС-ын Үндэсний зөвлөхөд жил тутам явуулах
  - Шинээр томилогдсон ИТС-ыг хариуцан мэргэжилтэнд ИТС, ИТС-ын Ажлын албаны талаарх мэдээлэл өгч, заавар, зөвлөлгөө өгөх.

## **1.9 ИТС-ын Монгол улс дахь Ажлын нэгжийн үйл ажиллагаа, уулзалт**

Ажлын нэгжүүд болон Үндэсний зөвлөх Монгол улс дахь бүх ажлын нэгжүүдтэйгээ харилцан тохирсоны үндсэн дээр тогтмол уулзалтаа төлөвлөн зохион байгуулна. Уг уулзалтыг улиралд нэг удаа зохион байгуулна.

ИТС-ын Монгол дахь Ажлын нэгжүүдийн уулзалт бол ИТС-ын Монгол дахь Оролцогч талуудын үндсэн платформ бөгөөд уулзалт бүр дээр дараах байдлаар ажлын нэгжүүд оролцоно:

- Монгол улс дахь ИТС-ын механизмийн хүрээнд хамтын ажиллагааны чухал ач холбогдолтой үйл ажиллагааны талаар нэгдсэн зөвшилцөлд хүрэх;
- Монгол дахь ИТС-ын хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын талаар дүгнэх, харилцан хэлэлцэх, төлөвлөх;
- ИТС-ын тухай нэгдсэн ойлголтыг бэхжүүлэх, мэдээлэл солилцох, ялангуяа шинээр Ажлын нэгжээр эсвэл хариуцах мэргэжилтнээр томилогдсон ажилтанд холбогдох мэдээлэл өгөх;
- ИТС-ын хүрээнд төслийн санал гаргах, боловсруулах, хэлэлцэх, санал солилцох;
- ЗХА-ийн бүс нутгийн интеграцитай холбоотойгоор Монгол улсад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэх, шийдэл олох;
- ИТС-аас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх.

ИТС-ын Монгол дахь Ажлын нэгжүүдийн уулзалтын албан ёсны хэл нь англи болон монгол хэл байна.

## 1.10 Үйл ажиллагааны санхүүжилт

### ИТС-ын Монгол улсын Ажлын нэгжүүдэд гишүүнчлэлийн төлбөр байхгүй.

ИТС-ын Монгол дахь Ажлын нэгжүүдийн уулзалтын зохион байгуулалтын зардлыг Монгол улсын Сангийн яам бусад дэмжигч талуудын тусламжтайгаар хариуцах бөгөөд одоогийн байдлаар ГОУХАН-ийн SCSI хөтөлбөрийн дэмжлэгтэй цуврал уулзалтууд зохион байгуулаад байна.

ИТС-ын Зөвлөл/Хороодын уулзалт, хурлын санхүүжилтийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг тус гарын авлагын 2-р Хэсгийн ИТС-ын Зөвлөл/хороодын уулзалт, хурлын тухай мэдээллээс авна уу.

## 1.11 Төсөл боловсруулалт

ИТС-ын төслийг дараах хоёр байдлаар ангилдаг:

- **Техникийн туслалцааны төсөл** нь бодлого зохицуулалт, байгууллага, хууль эрх зүйн саад тогтворыг арилгахад чиглэсэн байдаг бол
- **Техник туслалцааны бус төсөл** эсвэл Хөрөнгө оруулалтын төсөл нь банк болон хувийн салбарын хөрөнгө оруулагчдын оролцоотой хэрэгждэг.

### 1.11.1 Техникийн туслалцааны төсөл

ИТС-ын Ажлын албанаас “ИТС-ын Техникийн туслалцааны төсөл боловсруулах гарын авлага”-ыг гаргаж 2016 онд БНСУ-ын Сөүл хотноо болсон 16 дахь удаагийн ЗХ-ний хурлаар баталсан. Тус гарын авлагад ИТС-ын төсөл боловсруулах үе шатуудын талаар тухайлбал төслийн санал боловсруулах, төсөл сонгох, батлах үйл явц, төсөл хэрэгжүүлэх болон үнэлэх, мөн ИТС-ын хэрэгжүүлсэн төслүүдийн шилдэг туршлага, онцлогуудыг хэрхэн тусгах тухай заавар, зөвлөлгөө өгсөн байдаг. Энэ нь Гишүүн орнууд хийгээд гадны эх сурвалжаас санхүүжилт татах боломжтой чанартай төслийн санал боловсруулан танилцуулахад дөхөм үзүүлдэг баримт бичиг юм.

